



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн 14.2.3 дахь заалт, 14.3 дахь хэсэг, Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт, зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд өгсөн Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, төсвийг үр ашигтай удирдах, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын төсвийн багцын нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын дарга /төсвийн төвлөрүүлсэн болон шууд захирагч/ нарт дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

1.1 Санхүүгийн сахилга батыг чанд сахиж, тайлан тэнцлийн дансны үлдэгдэл, үзүүлэлтүүдийг анхан шатны баримтуудтай тулган баталгаажуулах, илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх, "хязгаарлалттай" дүгнэлт авсан байгууллагын удирдлагууд санхүү бүртгэлийн үйл ажиллагаагаа сайжруулах;

1.2 Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах, авлага, өглөг урьдчилгаа дансны үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, олон жилийн настай өр, авлагыг барагдуулах ажлуудыг зохион байгуулж, биелэлтийг 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэх;

2. Сайдын төсвийн багцын 2020 оны нэгтгэсэн тайланд өгсөн үүрэг даалгаварын дагуу санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар сүүлийн 6 жил дараалан "хязгаарлалттай" дүгнэлт авсан "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч Д.Даваадоржид хариуцлага тооцохыг тус компанийн гүйцэтгэх захирал Р.Батсүхэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/-д даалгасугай.

САЙД  Л.ХАЛТАР

